



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/31

Алтай хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед
зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 2022 оны 01 дүгээр хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2022 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 01 дүгээр сарын 26-ны өдрийг дуустал хугацаанд спорт заал, фитнесс, усан бассейн, сүм хийдийн үйл ажиллагааг 50 хувийн дүүргэлттэйгээр 10:00-20:00 цагийн хооронд, нийтийн хоол үйлдвэрлэлийн газар, ресторан, зоогийн газруудын үйл ажиллагааг 10:00-22:00 цагийн хооронд, баар, караоке, паб-ын үйл ажиллагааг 10:00-20:00 цагийн хооронд явуулахыг тус тус зөвшөөрч, 20:00 цагаас хойш архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, цагийн хязгаар болон дэглэм зөрчсөн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 он А/03 дугаар захирамжийн 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР